

Аудитын код: САГ/2018/5/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Захиалагч:

“Санхүүгийн Аудитын Газар”-ын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас:261885 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитор Б.Сэржмядаг

Утас: 261628 Цахим хаяг: serjmyadaqb@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

“Хүлэгтхүннү Аудит” ХХК Гүйцэтгэх захирал Е.Оюундэлгэр

Утас:88084464; 70140505 Цахим хаяг: oyundelger@hulegthunnu.mn

Аудитор Ё.Наранбилэг

Утас: 88003980 Цахим хаяг: naranbileg@hulegthunnu.mn

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт.....	4
2.6	Зорилтот түвшингийн гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	6
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	7
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	7
2.9.1	Авлагын талаар.....	7
2.9.2	Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дахин үнэлгээний талаар.....	7
2.9.3	Өр төлбөрийн талаар.....	8
2.9.4	Урьдчилж орсон орлогын талаар.....	8
2.9.5	Бараа материалын талаар.....	8
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	9
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	10
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	10
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:.....	10
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3	Менежментийн захидал.....	12
3.1	Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн талаар.....	13
3.2	Урьдчилж орсон орлогын талаар.....	14
3.5	Ажилчдын талаар.....	16
3.6	Найдваргүй авлагын талаар.....	15
3.7	Урьдчилж төлсөн зардлын талаар.....	17
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшин.....	18
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	18
4.2	Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан.....	19
4.3	Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	21
4.5	Аудит хийгдсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан.....	22

МОНГОЛЫН ИРГЭНИЙ АГААРЫН
ТЭЭВЭР ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ Т.ТАМИР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл


Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг



Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК (цаашид “МИАТ ТӨХК” гэх)-ийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал Т.Тамир танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх, хүчинтэй хугацаа нь дууссан зорчигчийн тийзний орлого хүлээн зөвшөөрөлт, урьдчилж төлсөн зардлын маргаантай асуудлыг шийдвэрлэх, найдваргүй авлагын хасагдуулга тооцсон авлагын асуудлыг шийдвэрлэх, олон жил байнгын ажлын байранд хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллаж байгаа ажилчдын асуудлыг хөдөлмөрийн хуульд нийцүүлэн шийдвэрлэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу МИАТ ТӨХК –ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

МИАТ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захирал болон ерөнхий нягтлан бодогч нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

01

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 15-наас 2018 оны 3 дугаар сарын 14-ний хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 15-нд эцэслэн баталгаажуулж, МИАТ ТӨХК-ийн гүйцэтгэх захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Хүлэгтхүннү Аудит ХХК-ийн аудитор Ё.Наранбилэгээр ахлуулсан баг бүрэлдэхүүн гүйцэтгэж, чанарын хяналтын менежер Е.Оюундэлгэр хяналт тавьж хэрэгжүүлэв.

Аудитаар МИАТ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг МИАТ ТӨХК-ийн 2018 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 01/1173 дугаар албан бичгээр Хүлэгтхүннү аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

МИАТ ТӨХК санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт /СТОУС/, Сангийн сайдын 2017 оны 361 дугаар тушаалаар баталсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулга бэлтгэх заавар” зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.14, 76.1.18 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.1 дэх заалт, Компанийн дүрмийн 7.3.4, 7.3.14 дэх заалтыг тус тус үндэслэн МИАТ ТӨХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 02/12 тоот тогтоолоор бүтцийг 675 орон тоотойгоор баталсан байна.


МИАТ ТӨХК-ийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

Зам, тээвэр, холбооны сайдын (хуучнаар) 1993 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 180 дугаар тушаалаар тухайн үеийн МИАТ нэгтгэлийг МИАТ ТӨХК болон Иргэний агаарын тээврийн удирдах газар болгон хуваан зохион байгуулсан ба Зам, тээврийн хөгжлийн яаманд харьяалагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

МИАТ ТӨХК нь агаарын тээвэр, агаарын хөлгийн түрээс, техникийн засвар үйлчилгээ, газрын үйлчилгээ зэргээс ихэнх орлогоо бүрдүүлдэг бөгөөд тэдгээрийг үйл ажиллагааны үндсэн чиглэлээ болгон тодорхойлсон байна.

МИАТ ТӨХК-ийн ТУЗ-ийн 2015 оны 01/15 дугаар тогтоолоор баталсан “Компанийн 2015-2017 оны бизнес төлөвлөгөө”-нд зааснаар “Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Монголын үндэсний агаарын тээвэрлэгч болох” гэсэн алсын хараатай, “Найдвартай, чанартай, үр өгөөжтэй агаарын тээврийн үйлчилгээгээр Монголыг дэлхийтэй холбосон үндэсний тэргүүлэгч компани байна” гэсэн эрхэм зорилготойгоор ажилласан байна.

2018-2020 онд МИАТ ТӨХК нь нислэгийн аюулгүй ажиллагааг найдвартай ханган, Азийн болон Евро-Азийн бүс нутгийн агаарын тээврийн зах зээлд өөрийн гэсэн байр суурь, өрсөлдөх чадвар бүхий найдвартай агаарын тээвэрлэгч болох зорилго тавин ажиллаж байна.



Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Дэвшүүлсэн стратеги, зорилгоо хэрэгжүүлэхээр дараах зорилтуудад хүрэхээр ажиллаж байна. Үүнд:


- Нислэг үйлдэж байгаа уламжлалт зах зээлийн хэмжээг өргөтгөхийн тулд нислэгийн давтамжийг нэмэгдүүлэх;
- Компанийн үйл ажиллагааг олон улсын агаарын тээврийн зах зээл дээр өрсөлдөхүйц хэмжээнд хүргэж, хөгжүүлэх;
- Ази, Европын 6-7 чиглэлд шинээр нислэг нээж, зах зээлээ өргөжүүлэх;
- Хэрэглэгчдийн сэтгэл ханамж, нислэгийн аюулгүй байдлыг эрхэмлэн үйлчилгээний чанар, соёлыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулахын зэрэгцээ SKY TRAX-ын үйлчилгээний 4 одтой агаарын тээвэрлэгч болох;
- Нислэгийн давтамж, чиглэлээ нэмэгдүүлснээр агаарын хөлгийн ашиглалтыг сайжруулж, нислэгийн цагийг олон улсын дундаж түвшинд ойртуулах;
- Зөвхөн зорчигч тээврийн үйлчилгээнээс нийт орлогын 80 гаруй хувийг бүрдүүлдэг байдлыг өөрчлөх зорилгоор газрын үйлчилгээ, транзит тээвэр, агаарын хөлгийн засвар үйлчилгээ, ачаа тээвэр, шатахуун сумлагаа, бизнес танхим, агаарын худалдаа, сургалт зэрэг үйл ажиллагааны бусад төрлөөс олох орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Агаарын тээврийг Монгол Улсын эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулан, аялал жуулчлалын салбартай хамтран ажиллах арга хэлбэрийг боловсронгуй болгох;
- Шатахуунаас үүдэлтэй эрсдэлийг бууруулах зорилгоор олон эх үүсвэрээс шатахуун нийлүүлэх арга замыг нэвтүүлж гадаад, дотоодын нийлүүлэгч нартай хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг болно.

МИАТ ТӨХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000-1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Хувь хүнийн орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль зэргийг гол шалгуур болголоо.

Аудитаар МИАТ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай



илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлангийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

МИАТ ТӨХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

МИАТ ТӨХК нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2007 онд шинэчлэн баталж, 2014 онд өөрчлөлт оруулан үйл ажиллагаандаа мөрдөж байна. Санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн “Microsoft Dynamics Nav” програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

МИАТ ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хэвийн гэж үзлээ.

Дотоод аудитын алба 2017 онд МИАТ ТӨХК-ийн хэмжээнд үндсэн ажлын талаар 17, бусад ажлын талаар 3 шалгалт хийхээр төлөвлөсөн байна. Тайлант жил төлөвлөгөөт шалгалт 12, төлөвлөгөөт бус шалгалт 8, гомдол 1, албан бичгээр 2 шалгалт нийт 23 удаагийн шалгалт хийж, 1,171.3 сая төгрөгийн 71 зөвлөмж өгснөөс 251.8 сая төгрөгийн 11 зөвлөмжийг бүрэн биелүүлж, 9.8 сая төгрөгийн 6 зөвлөмж хэрэгжээгүй, үлдсэн 909.7 сая төгрөгийн 54 зөвлөмж хэрэгжилтийн шатандаа байна.

Дотоод аудитын алба 2017 онд МИАТ ТӨХК-ийн гадаад дахь 5 төлөөлөгчийн газруудад 8 удаагийн хяналт шалгалтыг хийж 142.3 сая төгрөгийн зөрчлийг илрүүлсэн байна. Үүнээс Токио дахь төлөөлөгчийн газрын 4 билет бичигч нийт 126.7 сая төгрөгийн билет борлуулалтын мөнгийг төлөөлөгчийн газрын Ерөнхий менежерт тушаагаагүй, хувьдаа ашигласан байсныг илрүүлсэн ба 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 26.6 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

2.6 Зорилтот түвшингийн гүйцэтгэл, түүний талаарх тайлбар, тодруулга

МИАТ ТӨХК нь олон улсын 8 чиглэлд тогтмол нислэг, Ази, Европын 20 гаруй чиглэл, орон нутгийн 1 чиглэлд захиалгат нислэг хийж байна. 2017 оны үйл ажиллагааны үндсэн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл зэрэг гол үзүүлэлтүүдийг доорх хүснэгтүүдэд үзүүлэв.

2017 оны нислэг тээвэрлэлтийн зорилтот түвшин, түүний гүйцэтгэл:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	Өөрчлөлт (тоогоор)	Өөрчлөлт (хувиар)
Аяллын тоо	Тоо	2,043	2,006	01	(37) -2%
Нислэгийн зам	мян.км	8,132.8	8,091.5	01	(41) -1%

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

МИАТ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

Нислэгийн цаг	Цаг	10,849	12,027	1,178	11%
Зорчигч тээвэрлэлт	Хүн	585,855	610,391	24,536	4%
Ачаа тээвэрлэлт	Тонн	3,010.0	2,970.0	(40)	-1%

2017 оны нислэг тээвэрлэлтийн гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан байдал:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 оны гүйцэтгэл	2017 оны гүйцэтгэл	Өөрчлөлт (тоогоор)	Өөрчлөлт (хувиар)
Аяллын тоо	Тоо	1,667	2,006	339	20%
Нислэгийн зам	мян.км	7,145.9	8,091.5	946	13%
Нислэгийн цаг	Цаг	10,627	12,027	1,400	13%
Зорчигч тээвэрлэлт	Хүн	492,046	610,391	118,345	24%
Ачаа тээвэрлэлт	Тонн	2,902.7	2,970.0	67	2%

2017 оны санхүүгийн орлого, зардал, ашгийн зорилтот түвшин, түүний гүйцэтгэл:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны төлөвлөгөө	2017 оны гүйцэтгэл	Өөрчлөлт (тоогоор)	Өөрчлөлт (хувиар)
Үйл ажиллагааны орлого	сая.төг	319,180	389,311	70,131	22%
Үйл ажиллагааны зардал	сая.төг	290,346	326,581	36,235	12%
Бусад ашиг (алдагдал)	сая.төг	(12,962)	(2,833)	10,129	(78%)
Цэвэр ашиг	сая.төг	12,354	48,157	35,804	290%


Үйл ажиллагааны орлого төлөвлөсөн хэмжээнээс 22 хувиар буюу 70,131.4 сая төгрөгөөр өсөхөд зорчигч тээвэрлэлтийн орлого 55,016.2 сая төгрөгөөр, нойтон түрээсийн нислэгийн орлого 11,536.1 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Үйл ажиллагааны зардал төлөвлөсөн хэмжээнээс 12 хувиар буюу 36,235.0 сая төгрөгөөр өсөхөд онгоцны засвар, техник үйлчилгээтэй холбоотой 4 төрлийн зардал 11,870.6 сая төгрөгөөр, газрын техник үйлчилгээний зардал 6,217.0 сая төгрөгөөр, онгоцны нисэх бүрэлдэхүүний цалингийн зардал 3,428.2 сая төгрөгөөр, онгоцны түрээсийн зардал 3,204.4 сая төгрөгөөр, борлуулагч агентийн шимтгэл 3,519.4 сая төгрөгөөр, СИТА суудал захиалгын системийн зардал 3,853.5 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Бусад ашиг (алдагдал) өмнөх төлөвлөсөн хэмжээнээс 78 хувиар бага буюу 10,129.0 сая төгрөгөөр буурахад гадаад валютын ханшийн хэлбэлзэл (хаалтын ханш төлөвлөсөнөөс бага байсан) голлох нөлөөг үзүүлсэн байна.

2017 оны орлого, зардал, ашгийн гүйцэтгэлийг өмнөх оны гүйцэтгэлтэй харьцуулсан байдал:

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2016 оны гүйцэтгэл	2017 оны гүйцэтгэл	Өөрчлөлт (тоогоор)	Өөрчлөлт (хувиар)
Үйл ажиллагааны орлого	сая.төг	293,805	389,311	95,506	32%



Үйл ажиллагааны зардал	сая.төг	245,690	326,581	80,891	33%
Бусад ашиг (алдагдал)	сая.төг	(42,255)	(2,833)	39,422	(93%)
Цэвэр ашиг	сая.төг	5,860	48,157	42,297	722%

Үйл ажиллагааны орлого өмнөх оноос 95,505.8 сая төгрөгөөр буюу 32 хувиар өсөхөд зорчигч тээвэрлэлтийн орлого (YQ, YR-ийн орлого багтсан) 64,026.8 сая төгрөгөөр, захиалгат нислэгийн орлого 14,092.1 сая төгрөгөөр, интерлайн зорчигчийн орлого 9,866.1 сая төгрөгөөр тус тус өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Үйл ажиллагааны зардал өмнөх оноос 80,890.8 сая төгрөгөөр буюу 33 хувиар өсөхөд онгоцны шатахууны зардал 23,506.4 сая төгрөгөөр, онгоцны түрээсийн зардал 10,492.9 сая төгрөгөөр, онгоцны засвар үйлчилгээний нөөцийн зардал 7,104.4 сая төгрөгөөр, хуваарьт засварын зардал 7,278.8 сая төгрөгөөр, СИТА суудал захиалгын системийн зардал 4,081.4 сая төгрөгөөр, нисэх бүрэлдэхүүний цалингийн зардал 4,140.2 сая төгрөгөөр, борлуулагч агентийн шимтгэлийн зардал 3,331.8 сая төгрөгөөр, зорчигчийн хүнсний зардал 3,324.0 сая төгрөгөөр, аэронавигацийн хураамж 3,069.6 сая төгрөгөөр өссөн нь голлох нөлөөг үзүүлсэн.

Бусад ашиг (алдагдал) өмнөх оноос 39,422.0 сая төгрөгөөр буурахад гадаад валютын ханшийн хэлбэлзэл голлох нөлөөг үзүүлсэн байна. МИАТ ТӨХК нь ханшийн зөрүүнээс 2016 онд 39,796.1 сая төгрөгийн алдагдал хүлээж байсан бол 2017 онд 6,019.4 сая төгрөгийн олз олсон байна.

Алтманы индексээр тооцоолсон 2015-2017 оны дампуурлын эрсдлийн үзүүлэлт:


Эрсдлийн түвшин	Интервал	2015	2016	2017
Дампуурлын эрсдэл өндөр	$Z < 1.8$	0.94	0.95	
Дампуурлын эрсдэл дундаж	$1.9 < Z < 2.7$			2.10
Дампуурлын эрсдэл бага	$2.8 < Z < 2.9$			
Дампуурлын риск маш бага	$Z > 3$			

2017 оны санхүүгийн байдал, орлого үр дүнгийн гүйцэтгэлээр “дампуурлын эрсдэл өндөртэй”-ээс “дампуурлын эрсдэл дундаж” түвшинд шилжиж эрсдэл нэг түвшнээр буурсан байна.

Эдийн засгийн зорилтот түвшин, гүйцэтгэлийн мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

2.7 Шилэн дансны мэдээлэл

МИАТ ТӨХК нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас www.miat.com сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний гүйцэтгэлийн ерөнхий мэдээлэл, концессийн мэдээлэл, худалдан авах ажлын гүйцэтгэлийн тайланг оруулсан байна.



2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 14 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 82 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Авлагын талаар

Mega Global Air Service компанитай байгуулсан нойтон түрээсийн гэрээгээрх сүүлийн 2 нислэгийн төлбөрийг урьдчилж авч чадаагүйгээс 1,513.9 сая төгрөг (\$623,731)-ийн авлага үүссэн байна. Уг компани Малдив Улсад үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2017 онд болсон төрийн эргэлт, иргэний хөдөлгөөний улмаас компанийн үйл ажиллагаа нь доголдож 2018 оны эхээр нислэг үйлдэх эрхээ хураалгаж, 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдөр өөрийн саналаар дампуурлаа зарласан тухайгаа МИАТ компанид мэдэгдсэн байна.

Энэ байдал нь НББОУС 39(59)-д “... Санхүүгийн хөрөнгө ... үнэ цэнэ буурсан гэх бодитой нотолгоонд ... зээлдэгч нь дампуурах ... багтана”, 39(63)-д “... хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэх бодитой нотолгоо байгаа бол уг гарзын дүнг тухайн хөрөнгийн дансны үнийн ба ... ирээдүйн мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ” гэж заасны дагуу хасагдуулга байгуулах нөхцөл бүрдүүлсэн байна.


Шийдвэрлэсэн нь: 2017 оны санхүүгийн тайланд найдваргүй авлагын хасагдуулга, найдваргүй авлагын зардлыг 1,513.9 сая төгрөгөөр нэмж залруулсан.

2.9.2 Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дахин үнэлгээний талаар

МИАТ ТӨХК нь 2009 оноос хойш дараа үеийн хэмжилтэнд дахин үнэлгээний загвар ашигладаг 137,146.0 сая төгрөгийн дансны үнэтэй үндсэн хөрөнгүүдэд болон биет бус хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийлгээгүй байна. Энэ нь НББОУС 16(31), 38(75)-д “... дахин үнэлгээг дансны үнэ болон бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хийх шаардлагатай”, НББОУС 16(34), 38(79)-д “... дахин үнэлгээ хийх давтамж нь дахин үнэлж буй хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаална” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

МИАТ ТӨХК-ийн удирдлагын зүгээс Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас “2018 онд төрийн өмчийн зарим (барилга, газар эзэмших эрх) хөрөнгүүдэд нэгдсэн журам, зааврын дагуу дахин үнэлгээ хийгдэнэ” гэж мэдэгдсэн бөгөөд дахин үнэлгээг хийлгэх бэлтгэл ажлыг хангах, үнэлгээг гүйцэтгүүлэхээр ажлын хэсэг байгуулан ажиллаж байгаагаа мэдэгдсэн.

Шийдвэрлэсэн нь: Дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загварыг ашигладаг үндсэн хөрөнгүүдэд болон биет бус хөрөнгүүдэд 2018 онд дахин үнэлгээ хийлгэх зөвлөмж өгсөн.



2.9.3 Өр төлбөрийн талаар

АНУ-ын Aersale компаниас түрээслэсэн онгоцны хөдөлгүүрийн ашиглалтын блок цаг дуусч, түрээслүүлэгчээс сольж тавих хөдөлгүүрийн талаарх мэдээллийг ирүүлсэн байна. МИАТ компанийн хувьд ИНЕГ-ын дүрмийн дагуу FAA, EASA-р баталгаажсан хөдөлгүүр ашиглах шаардлагатай байдаг ба түрээслүүлэгчийн хөдөлгүүрийн зарим эд анги нь дээрх баталгаажуулагч байгууллагаар баталгаажуулаагүй байсан тул компанийн зүгээс сольж өгөхийг хүссэн боловч хүсэлтийг хангаагүй. 2016 оны 4 дүгээр сараас онгоц нислэг үйлдэх боломжгүй болж зогссон бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр 2016 оны 6 дугаар сард онгоцыг буцаасан байна. Түрээслүүлэгч талаас МИАТ ТӨХК-ийг гэрээгээ зөрчсөн гэж 27 сарын түрээсийн төлбөрт 9.0 сая доллар нэхэмжилж, дараа нь АНУ-ын шүүхэд хандсан байна. МИАТ компани удаан хугацаанд шүүхийн асуудал сунжирсан тохиолдолд хуульчийн зардал ихсэх, хэрэв шүүх дээр ялагдал хүлээвэл нэмж алдагдал хүлээх магадлалтай байсан тул хэлэлцээр хийж 7,365.0 сая төгрөг (\$3,000,000)-ийг төлөхөөр эвлэрлийн гэрээг байгуулсан ба, уг нөхөн төлбөрийг түрээсийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн.

Энэ нь СТОУС-ын СҮБ(4.3)-д “Гарз нь ... аж ахуйн нэгжийн ердийн үйл ажиллагааны үр дүнд үүсч, эсвэл үүсэхгүй ч байж болно” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны санхүүгийн тайланд хүү, торгуулийн зардлыг 7,365.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, түрээсийн зардлыг 7,365.0 сая төгрөгөөр бууруулж залруулсан.

2.9.4 Урьдчилж орсон орлогын талаар

Хүчинтэй хугацаа нь дууссан зорчигчийн тийзтэй холбоотойгоор үүссэн урьдчилж орсон орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх асуудлыг зохицуулсан компанийн дотоод журам, орлогод хүлээн зөвшөөрч бүртгэсэн практик байхгүйн улмаас олон жилийн туршид хуримтлуулан бүртгэж ирсэн байна. Олон улсын агаарын тээврийн холбоо (IATA)-с гаргасан “IATA General Conditions of Carriage (Passenger and Baggage)” баримт бичгийн 11.6, 11.6.1-д “зорчигчийн тийзний хүчинтэй хугацаа дууссан бол агаарын тээврийн компани нь өөрийн орлого болгож болно” гэж заасан байна.

Энэ нь НББОУС 8(10)-д “Ажил гүйлгээ, бусад үйл явдал буюу нөхцөл байдлыг бүртгэхэд тусгайлан хэрэглэх СТОУС байхгүй тохиолдолд удирдлага ... мэдээлэлд нөлөө үзүүлэх нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулах болон хэрэглэхдээ өөрсдийн мэргэжлийн шийдлийг ашиглана”, 8(12)-д “... мэргэжлийн шийдлийг гаргахдаа удирдлага ... хүлээн зөвшөөрсөн салбарын практик туршлагыг мөн адил харгалзан үзэх хэрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хүчинтэй хугацаа дууссан зорчигчийн тийзнээс үүссэн урьдчилж орсон орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх нягтлан бодох бүртгэлийн бодлого, дүрэм, журмыг боловсруулж, мөрдөх зөвлөмж өгсөн.

2.9.5 Бараа материалын талаар

Эрсдэлтэй гэж түүвэрлэгдсэн 10 сая төгрөгөөс дээш нэгжийн өртөгтэй 151 ширхэг сэлбэгийг түүвэрлэн авч тооллого, баримтын шалгалтыг хийж түүвэрлэхэд 2010-2017 онуудад онгоцны засвар үйлчилгээнд тавьж олгосон 1,791.7 сая төгрөгийн 59 ширхэг сэлбэгийн зарлагыг, 17.7 сая төгрөгийн 1 ширхэг сэлбэгийн буцаалтыг хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна.

САГ-2018/5/СТА-ТӨҮГ

Энэ нь СТОУС-ын СҮБ(4.50)-д “Гарсан зардал болон олсон орлогын хоорондох шууд хамаарлыг үндэслэн орлогын тайланд зардлыг хүлээн зөвшөөрнө” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны санхүүгийн тайланд 1,809.4 сая төгрөгийн сэлбэгийн үл хүлээн зөвшөөрөлтийг нэмж залруулсан.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал


МИАТ ТӨХК-д дараах анхаарал татахуйц чухал асуудлууд байна. Үүнд

- “Бойнг 767-300ER” агаарын хөлгийг худалдан авахад АНУ-ын Private Export Finding Corporation (PEFCO) компаниас 10 жилийн хугацаатай 77 сая америк долларын зээлийг 2013 онд авсан. PEFCO зээлийн гэрээнд зээл төлөгдөж дуусах хүртэл Бойнг 767-300ER JU1021 агаарын хөлөг нь Эм Эн Жи Лийзинг ХХК-ийн өмчлөлд байх ба зээл төлөгдөж дууссаны дараа уг онгоц МИАТ ТӨХК-ийн өмчид шилжихээр заасан байна.
- Бойнг 737-300ER JU1021 агаарын хөлгийг худалдан авах зорилгоор Deutsche bank A.G, Hongkong-с 2012 оны 12 дугаар сарын 23-ны өдөр авсан 20.0 сая америк долларын зээлийн эргэн төлөлт 2018 оны 12 дугаар сарын 23-ны өдөр хийгдэхээр байна.
- Тайлант жилийн эцэст МИАТ ТӨХК-д нэг томоохон шийдэгдээгүй шүүхийн нэхэмжлэл байсан нь БНСУ-ын Сэй Юү Эйр хувьцаат компани болон МИАТ ТӨХК-ийн хооронд 2014 онд байгуулсан “МИАТ ТӨХК-ийн Улаанбаатар-Сөүл, Сөүл-Улаанбаатар чиглэлийн нислэгийн зорчигч болон ачааны борлуулагчийн бүх эрхийг бүхэлд нь шилжүүлэх” гэрээг үндэслэлгүйгээр цуцалсан эсэхтэй холбоотойгоор 2017 оны 2 дугаар сард МИАТ ТӨХК-ийн эсрэг иргэний журмаар БНСУ-ын Сөүл хотын шүүхэд нэхэмжлэл гаргаж үндэслэлгүйгээр гэрээ цуцалсны хохиролд МИАТ ТӨХК-аас 10,000.0 сая воны нэхэмжлэл гаргасан.

МИАТ ТӨХК удирдлага нь компанийн Бодлого, төлөвлөлтийн газрын захирлаар ажиллаж байсан С.Билэгсайхан өөрийгөө МИАТ ТӨХК-ийг төлөөлөн гэрээ хийх эрхтэй хэмээн Сэй Юү Эйр компанийн удирдлагад буруу мэдээлэл өгч эрх мэдлээ хэтрүүлэн гарын үсэг зурсан нь Монгол Улсын Компанийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг болон компанийн дотоод дүрэм, журмыг зөрчсөн гэдэг үндэслэлээр Сэй Юү Эйр хувьцаат компанийн эсрэг иргэний хэргийн нэхэмжлэлийг 2018 оны 2 дугаар сард Монгол Улсын Хан-Уул дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргасан байна. Уг үндэслэлээр МИАТ ТӨХК-ийн талд нааштай шийдэгдэнэ гэдэгт итгэлтэй байгаа учраас ямар нэг өр төлбөр бүртгээгүй болно.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

МИАТ ТӨХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар сэлбэгийн үл хүлээн зөвшөөрөлт болон үлдэгдэл, хүчинтэй хугацаа нь дууссан зөрчигчийн тийзний орлого хүлээн зөвшөөрөлт, 138, 669.2 сая төгрөгийн дансны үнэтэй үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн дахин үнэлгээ хийгдсэн байдлыг шалгах нь зүйтэй гэж үзлээ.



2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

МИАТ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 25,776.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 23,479.7 сая төгрөгийн алдааг залруулж, 2,296.7 сая төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгсөн.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

МИАТ ТӨХК-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд “Пантер мидланд аудит” ХХК аудит хийж, нийт 27,732.18 сая төгрөгийн зөрчилд 15 зөвлөмж өгч, “зөрчилгүй” санал дүгнэлт өгсөн байна. МИАТ ТӨХК тайлант хугацаанд 12 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. 2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжүүлээгүй 2 зөвлөмжийг хэрэгжүүлж, 1 зөвлөмжид дахин зөвлөмж өгсөн.

Хэрэгжүүлээгүй 1 зөвлөмжийн хувьд, 1993-2007 оны хооронд үүссэн 138 харилцагчийн 1,583.7 сая төгрөгийн авлага (2008 он, 2010 онд 100 хувь найдваргүй авлагын хасагдуулга тооцогдсон)-ын асуудал бөгөөд зарим харилцагчдын холбогдох материалыг бүрдүүлэн хууль, хяналтын байгууллагад өгсөн боловч хаяг тодорхойгүй үндэслэлээр буцаагдсан байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын цэвэр орлогыг сонгов.


МИАТ ТӨХК-ийн 2017 оны орлогын дэлгэрэнгүй тайлангийн борлуулалтын цэвэр орлого 389,311.0 сая төгрөг бөгөөд 1.0 хувиар буюу 3,893.1 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлын суурийг сонгохдоо өмнөх жилийн аудитын материаллаг байдлын суурийг харгалзан үзсэн ба материаллаг байдлын түвшинг тогтоохдоо хэрэглэгчдийн хэрэгцээ, өмнөх хоёр жилийн аудитын тайлангаар гарсан алдаа, зөрчлийн дүн, агуулгыг харгалзан үзсэн. Материаллаг байдлын тухай ойлголт болон энэхүү аудит дахь түүний хэрэглээг бид үйлчлүүлэгчтэй ерөнхий нөхцлийн хүрээнд хэлэлцсэн.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон АОУС-д нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар МИАТ ТӨХК-ийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.



Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Зөрчилгүй санал дүгнэлт:

МИАТ ТӨХК-ийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан /нийт 23 хуудас/-ыг хавсаргав.



3 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь МИАТ ТӨХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгийн талаар

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Компани 2009 оноос хойш дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд болон биет бус хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийлгүүлээгүй байгаа нь НББОУС 16(34)-д "... үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь мэдэгдэхүйц хувирамтгай ... жил бүр дахин үнэлгээ хийх шаардлагатай ... бодит үнэ цэнэ нь үл ялиг өөрчлөлттэй ... таван жилийн хугацаанд дахин үнэлэх шаардлагатай" гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайланд дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгүүд бодит үнэ цэнээрээ илэрхийлэгдэхгүй байх.

ҮАГ-ын зөвлөмж

Дахин үнэлгээг 2018 онд хийлгэх. НББОУС 16(32)-т "Газар, барилга байгууламжийн бодит үнэ цэнийг ихэвчлэн хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн үнэлгээчний тодорхойлдог зах зээлийн нотолгоонд суурилсан хөрөнгийн үнэлгээгээр тогтоодог" гэсэн стандартын заалтыг анхаарч, Сангийн яам болон Санхүүгийн зохицуулах хорооноос эрх авсан мэргэжлийн үнэлгээчнээр гүйцэтгүүлэх.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон хугацаанд багтаан дахин үнэлгээг хийж, зөвлөмжийн хэрэгжилтийг дахин үнэлгээний тайланг гарснаас хойш 15 хоногийн дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Стандартын дагуу дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгөд 2018 онд дахин үнэлгээ хийлгүүлнэ. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд хүргүүлэх болно.



3.2 Урьдчилж орсон орлогын талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Хүчинтэй хугацаа нь дууссан зорчигчийн тийзнээс үүссэн урьдчилж орсон орлогыг орлогод хүлээн зөвшөөрч бүртгэхтэй холбоотой компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, дүрэм, журам, орлогод хүлээн зөвшөөрч бүртгэсэн практик байхгүйн улмаас олон жилийн туршид хуримтлуулан бүртгэж ирсэн нь НББОУС 8(10)-д “Ажил гүйлгээ, ... нөхцөл байдлыг бүртгэхэд тусгайлан хэрэглэх СТОУС байхгүй тохиолдолд удирдлага ... өөрсдийн мэргэжлийн шийдлийг ашиглана”, 8(12)-д “... мэргэжлийн шийдлийг гаргахдаа удирдлага ... хүлээн зөвшөөрсөн салбарын практик туршлагыг мөн адил харгалзан үзэх хэрэгтэй” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайланд өр төлбөр (урьдчилж орсон орлого) илүү, эздийн өмч (хуримтлагдсан ашиг) багаар илэхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

СТОУС-ын болон IATA-аас гаргасан “IATA General Conditions of Carriage (Passenger and Baggage)”-н 11.6, 11.6.1 дэх заалтуудыг баримтлан хүчингүй билетийн мөнгийг орлогод тооцох бодлого, дүрэм, журмыг боловсруулж мөрдөх. Тодорхойлсон бодлогын дагуу 2018 оны санхүүгийн тайланд хүчингүй билетийн урьдчилж орсон орлогыг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

2018 онд СТОУС болон Олон улсын агаарын тээврийн холбооны дүрэмд нийцүүлэн хүчинтэй хугацаа нь дууссан зорчигчийн тийзний орлого хүлээн зөвшөөрөлтийн журам боловсруулж мөрдөнө. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд хүргүүлэх болно.

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

3.3 Найдваргүй авлагын талаар

Тэргүүлэх ач холбогдол №2

ҮАГ-ын ажиглалт

2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар найдваргүй авлагын нөөц байгуулагдсан 138 харилцагчийн 1,583.7 сая төгрөгийн авлагыг шийдвэрлэх зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь СТОУС-ын СҮБ(4.37)-д “Хүлээн зөвшөөрнө гэдэг нь ... хүлээн зөвшөөрөх шалгуурыг хангасан бөгөөд элементийн тодорхойлолтонд нийцсэн зүйлүүдийг баланс болон орлогын тайланд хамруулах үйл явцыг хэлнэ” гэж заасныг зөрчсөн байна.

ҮАГ-ын зөвлөмж

Нэхэмжлэх боломжтой авлагуудыг хууль, хяналтын байгууллагад өгч, төлүүлэх арга хэмжээг авах, нэхэмжлэх боломжгүй болсон (эзэн холбогдогч нь нас барсан, дампуурсан, хуулийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан г.м) авлагын нотлох мэдээллийг бүрдүүлэн холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн эрх бүхий этгээдээр шийдвэр гаргуулан найдваргүйд тооцож данснаас хасах. Энэхүү авлагатай холбоотой ажлыг компанийн хуульчдын багт хариуцуулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайланд хөрөнгийн шалгуур хангагдахгүй зүйлс толилуулагдах.

Үйлчлүүлэгчийн хариу

2018 онд зөвлөмжийн дагуу холбогдох ажлыг зохион байгуулж ажиллана. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд хүргүүлэх болно.



3.4 Ажилчдын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
----------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

2016.11.11-ний өдрийн МИАТ ТӨХК-ийн ТУЗ-ын тогтоолоор компанийн орон тоог 675 байхаар батлуулсан боловч Захиргаа, Хүний нөөцийн албанаас гаргаж өгсөн мэдээллээр үндсэн орон тоонд 675 ажилтан, түр орон тоонд 165 ажилтан, хөлсөөр ажиллах гэрээтэй 71 ажилтан, нийт 911 ажилтан тайлант онд ажилласан байна.

Компани байнгын ажлын байранд ажиллаж буй ажилтантай Хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулсан, Нийгмийн даатгалын тайландаа үндсэн ажилтнаар тайлагнадаг асуудал олон жилийн турш явж ирсэн нь “Хөдөлмөрийн тухай” хуулийн 24.1-д “Байнгын ажлын байранд хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээ байгуулахыг хориглоно”, мөн хуулийн 6.1-т “Ажилтан ... хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр, тэтгэмж авах, хөдөлмөрийн ба хамтын гэрээ, хэлэлцээрт заасан бусад эрх, хөнгөлөлт эдлэх эрхтэй” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Ажилтан нь хууль, тогтоомжоор олгосон үндсэн ажилтны эрхээ эдэлж, үүргээ хэрэгжүүлж чадахгүй болох.

ҮАГ-ын зөвлөмж

Хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөж ажиллах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ҮАГ-т хүргүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

ТУЗ-д аудитын зөвлөмжийг танилцуулж, шийдвэрлүүлнэ. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд хүргүүлэх болно.



3.5 Урьдчилж төлсөн зардлын талаар	Тэргүүлэх ач холбогдол №2
---	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Герман Улсын Lufthansa technik компаниас 2007 онд авсан онгоцны засвар үйлчилгээ болон 2015 онд гэрээгээ МИАТ компанийн зүгээс цуцласантай холбоотой төлбөрийн маргаан гарсан. 2017.12.31-ний өдрийн байдлаар МИАТ компанийн бүртгэлд Lufthansa technik компанид 713.0 сая төгрөг (\$291,037)-ийн урьдчилж төлсөн зардлын тооцоотой, харин Lufthansa technik компанийн зүгээс 498,135 ам.доллар, 54,718 еврог нэхэмжилж байгаа (\$65,239 алданги). МИАТ компанийн АХЗҮГ-аас маргаан үүссэнээс хойш Lufthansa technik компаниас хүлээн авсан 144,076 доллар, 54,718 еврогийн засвар үйлчилгээний баримт материалыг санхүүд гарган өгөөгүйгээс хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь СТОУС-ын СУБ(ЧШ4)-д “Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд үүгээр харуулах зүйлсийг зохистой бөгөөд үнэн зөв илэрхийлэх ёстой ...”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ ... аж ахуйн бүх ажил, гүйлгээ” гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайланд хуримтлагдсан ашиг илүү дүнгээр толилуулагдах, мөн урьдчилж төлсөн зардлаа авч чадахгүйд хүрэх, эсвэл гэрээний үүргээ зөрчсөний алдангийн эрсдэлд орох.

ҮАГ-ын зөвлөмж

Lufthansa technik компанитай маргааныг шийдвэрлэх ажлыг яаралтай эхлүүлэх, 2018 оны санхүүгийн тайланд уг компаниас худалдан авсан бараа, ажил үйлчилгээг хүлээн зөвшөөрч бүртгэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор ҮАГ-т хүргүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

2018 онд зөвлөмжийн дагуу холбогдох ажлыг зохион байгуулж ажиллана, уг компаниас авсан засвар үйлчилгээний баримт материалыг бүрдүүлэн хийгдсэн ажил гүйлгээг бүртгэнэ. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд хүргүүлэх болно.



4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, зорилтот түвшний

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ХӨРӨНГӨ		
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	28,091,326,081.99	42,072,916,386.21
Дансны авлага	23,819,427,677.56	22,442,974,076.30
Татвар НДШ-ийн авлага	485,844,547.96	1,099,849,725.75
Бусад авлага	-	4,223,230,073.81
Бараа материал	26,170,699,327.89	29,965,161,077.47
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	15,936,040,364.75	13,787,315,109.29
Эргэлтийн хөрөнгийн дүн	94,503,338,000.15	113,591,446,448.83
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
Үндсэн хөрөнгө	148,353,530,796.42	141,670,694,727.47
Биет бус хөрөнгө	1,302,154,209.47	2,408,851,202.78
Бусад эргэлтийн бус хөрөнгө	22,528,913,217.39	28,585,346,361.23
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	172,184,598,223.28	172,664,892,291.48
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	266,687,936,223.43	286,256,338,740.31
ӨР ТӨЛБӨР		
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Дансны өглөг	25,252,538,632.34	27,392,971,799.39
Цалингийн өглөг	409,613,626.00	750,819,384.30
Татварын өр	7,870,085,458.98	17,539,493,407.33
НДШ-ийн өглөг	-	-
Богино хугацаат зээл	64,253,129,805.99	85,573,660,209.58
Хүүний өглөг	1,959,795,064.54	2,133,466,895.84
Ногдол ашгийн өглөг	1,583,760,000.00	-
Урьдчилж орсон орлого	47,466,210,115.75	44,947,865,115.11
Нөөц /өр төлбөр/	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	61,004,594.05	1,664,920,490.70
Богино хугацаат өр төлбөрийн дүн	148,856,137,297.65	180,003,197,302.25
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
Урт хугацаат зээл	186,990,411,076.16	125,524,307,454.37
Бусад урт хугацаат өр төлбөр	40,046,557.20	3,327,262,337.43
Урт хугацаат өр төлбөрийн дүн	187,030,457,633.36	128,851,569,791.80
Өр төлбөрийн нийт дүн	335,886,594,931.01	308,854,767,094.05
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
Өмч: -Төрийн өмч	5,577,283,000.00	5,577,283,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	2,513,855,032.53	2,513,855,032.53
Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг	2,333,526,578.75	2,338,262,860.76
Хуримтлагдсан ашиг алдагдал	(79,623,323,318.86)	(33,027,829,247.03)
Эзэмшигчдийн өмчийн дүн	(69,198,658,707.56)	(22,598,428,353.74)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	266,687,936,223.43	286,256,338,740.31

4.2 Аудит хийгдсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	293,805,411,939.26	389,311,223,805.02
Борлуулсан барааны өртөг	218,445,300,731.27	294,388,904,212.70
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)	75,360,111,207.99	94,922,319,592.32
Түрээсийн орлого	211,433,459.60	165,666,667.17
Хүүний орлого	885,205,519.32	3,393,528,546.02
Ногдол ашгийн орлого	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-
Бусад орлого	-	929,363,284.55
Борлуулалт, маркетингийн зардал	1,136,679,444.81	1,384,004,367.42
Ерөнхий ба удирдлагын зардал	13,875,368,116.15	18,515,811,305.55
Санхүүгийн зардал	12,233,113,487.79	12,292,531,143.09
Бусад зардал	3,441,940,447.66	13,330,698,550.81
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(39,796,094,933.27)	6,009,364,617.15
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	7,763.36	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүсэх олз (гарз)	-	-
Бусад ашиг (алдагдал)	(113,799,110.76)	(147,199.08)
ТАТВАРЫН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)	5,859,762,409.83	59,897,050,141.26
Орлогын татварын зардал	7,106,418,304.96	11,739,940,527.88
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ (АЛДАГДАЛ)	(1,246,655,895.13)	48,157,109,613.38
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг алдагдал		-
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ АЛДАГДАЛ	(1,246,655,895.13)	48,157,109,613.38
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
Бусад олз (гарз)		-
Орлогын нийт дүн	(1,246,655,895.13)	48,157,109,613.38
НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)		



4.3 Аудит хийгдсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ЭЗНИЙ ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ	ХУРИМТЛАГДСАН АШИГ	НИЙТ ДҮН
2016 оны 01 сарын 01-ний өдрийн үлдэгдэл	5,577,283,000.00	2,513,855,032.53	2,338,262,860.76	(77,343,047,478.65)	(66,913,646,585.36)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				550,140,054.92	550,140,054.92
Залруулсан үлдэгдэл	5,577,283,000.00	2,513,855,032.53	2,338,262,860.76	(76,792,907,423.73)	(66,363,506,530.44)
Тайлант үеийн ашиг (алдагдал)				(1,246,655,895.13)	(1,246,655,895.13)
Өмчид гарсан өөрчлөлт			(4,736,282.01)		(4,736,282.01)
Зарласан ногдол ашиг				1,583,760,000.00	1,583,760,000.00
2017 оны 01-р сарын 01-ний өдрийн үлдэгдэл	5,577,283,000.00	2,513,855,032.53	2,333,526,578.75	(79,623,323,318.86)	(69,198,658,707.58)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				(1,561,615,541.55)	(1,561,615,541.55)
Залруулсан үлдэгдэл	5,577,283,000.00	2,513,855,032.53	2,333,526,578.75	(81,184,938,860.41)	(70,760,274,249.13)
Тайлант үеийн ашиг (алдагдал)				48,157,109,613.38	48,157,109,613.38
Бусад дэлгэрэнгүй орлого			4,736,282.01		4,736,282.01
2017 оны 12 сарын 31-ний өдрийн үлдэгдэл	5,577,283,000.00	2,513,855,032.53	2,338,262,860.76	(33,027,829,247.03)	(22,598,428,353.74)




4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	2016 оны 12-р сарын 31	2017 оны 12-р сарын 31
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	294,945,390,956.87	390,727,648,367.44
Бараа борлуулсан,үйчилгээ үзүүлсний орлого	292,669,520,787.42	389,849,692,498.95
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	1,601,142,725.95	298,850,443.50
Бусад мөнгөн орлого	674,727,443.50	579,105,424.99
Мөнгөн зарлагын дүн (-)	253,643,964,421.11	342,235,528,704.07
Ажиллагчдад олгосон мөнгө	29,466,274,346.23	36,228,818,218.16
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	4,912,555,984.00	6,222,170,980.00
Бараа материал худалдан авахад төлсөн	1,739,355,135.41	2,475,997,161.85
Ашиглалтын зардал төлсөн	506,687,878.92	577,837,348.28
Түлш шатахуун тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	61,745,193,047.34	92,129,240,775.10
Хүүний төлбөрт төлсөн	11,631,626,800.29	11,939,583,860.91
Татварын байгууллагад төлсөн	2,881,080,800.00	6,442,113,586.30
Даатгалын төлбөрт төлсөн	4,002,339,998.19	4,992,371,629.53
Бусад мөнгөн зарлага	136,758,850,430.73	181,227,395,143.94
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	41,301,426,535.76	48,492,119,663.37
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	885,472,518.77	2,455,598,647.91
Хүлээн авсан хүүний орлого	885,472,518.77	2,455,598,647.91
Мөнгөн зарлагын дүн (-)	1,872,044,918.92	1,940,442,369.00
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	922,966,482.92	1,885,549,809.50
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	949,078,436.00	14,310,000.00
Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	40,582,559.50
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний дүн	(986,572,400.15)	515,156,278.91
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	2,000,000,006.94	-
Зээл авсан, өрийн үнэт цаас авснаар хүлээн авсан	2,000,000,006.94	-
Мөнгөн зарлагын дүн (-)	34,622,358,880.63	35,636,000,563.47
Зээл, өрийн үнэт цаасны төлбөр төлсөн мөнгө	34,583,538,088.90	34,016,074,199.63
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	38,820,791.73	36,166,363.84
Төлсөн ногдол ашиг	-	1,583,760,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,622,358,873.69)	(35,636,000,563.47)
Валютын ханшны зөрүү	4,278,166,770.28	610,314,925.41
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	11,970,662,032.20	13,981,590,304.22
МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	16,120,664,049.79	28,091,326,081.99
МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	28,091,326,081.99	42,072,916,336.21



4.5 Аудит хийгдсэн зорилтот түвшний гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	ХЭМЖИХ НЭГЖ	2016 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛ	2017 ОН				ХАРЬЦУУЛАЛТ 2017/2016	
			ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	БИЕЛЭЛТ		ТООГООР	ХУВИАР
					ТООГООР	ХУВИАР		
1.Зорчигч тээвэрлэлт	мян.хүн	492.0	585.9	610.4	24.5	4.2%	118.3	24.1%
1.1. Тогтмол нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	399.5	414.1	444.9	30.8	7.4%	45.4	11.4%
1.2. Захиалгат нислэгийн зорчигч тээвэрлэлт	мян.хүн	92.5	171.8	165.5	(6.3)	-3.7%	72.9	78.8%
2. Ачаа тээвэрлэлт	тонн	2,902.7	3,010.0	2,970.0	(40.0)	-1.3%	67.2	2.3%
3. Зорчигч эргэлт (тогтмол аялал)	сая.хүн.км	950.8	1,012.3	1,072.7	60.5	6.0%	122.0	12.8%
4. Ачаа эргэлт	сая.тн.км	7.9	6.0	7.7	1.7	28.2%	(0.2)	-2.4%
5. Шилжүүлсэн тонн-километр (тогтмол аялал)	сая.тн.км	93.5	99.3	104.2	4.9	4.9%	10.8	11.5%
6. Нийт орлого	сая төг	294,902.1	319,619.8	393,799.8	74,180.0	23.2%	98,897.7	33.5%
6.1 Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны орлого	сая төг	267,588.9	299,724.9	364,182.0	64,457.1	21.5%	96,593.1	36.1%
6.2 Үндсэн бус үйл ажиллагааны орлого	сая төг	26,216.5	19,454.9	25,129.2	5,674.3	29.2%	(1,087.3)	-4.1%
6.3 Үйл ажиллагааны бус орлого	сая төг	1,096.7	440.0	4,488.6	4,048.6	920.1%	3,391.9	309.3%
7. Нийт зардал	сая төг	289,042.3	303,748.2	333,902.7	30,154.5	9.9%	44,860.4	15.5%
7.1 Агаарын тээврийн үндсэн үйл ажиллагааны зардал	сая төг	242,639.4	287,898.9	324,905.9	37,006.9	12.9%	82,266.4	33.9%
7.1.1 Үндсэн үйл ажиллагааны зардал	сая төг	217,062.9	260,379.9	294,388.9	34,009.0	13.1%	77,326.0	35.6%
7.1.2. Ерөнхий удирдлага, нэмэгдэл зардал	сая төг	25,576.5	27,519.0	30,517.0	2,997.9	10.9%	4,940.5	19.3%
- ерөнхий нэмэгдэл зардал (захиргаа, удирдлага)	сая төг	11,962.6	12,503.7	16,944.8	4,741.1	39.6%	4,982.3	41.6%
- зээлийн хүү	сая төг	12,040.6	13,514.0	12,001.2	(1,512.8)	-11.2%	(39.5)	-0.3%
- үндсэн хөрөнгийн элэгдэл (аг.хөлгөөс бусад)	сая төг	1,573.3	1,501.3	1,571.0	69.7	4.6%	(2.3)	-0.1%
7.2 Үндсэн бус үйл ажиллагааны зардал	сая төг	3,051.0	2,447.3	1,675.4	(771.9)	-31.5%	(1,375.6)	-45.1%

МИАТ ТӨХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудит

7.3 Валютын ханшийн зөрүүгийн бодит олз, гарзын хэлбэлзлийн дүн	сая төг	(9,733.1)	(10,186.9)	(7,227.2)	(2,959.6)	-29.1%	(2,505.8)	-25.7%
7.4 Валютын ханшийн зөрүүгийн бодит бус олз, гарзын хэлбэлзлийн дүн	сая төг	(30,063.0)	-	13,236.6	(13,236.6)		(43,299.6)	-144.0%
7.5 Үйл ажиллагааны бус зардал		3,555.8	3,215.0	13,330.8	10,115.7	314.6%	9,775.1	274.9%
8.Татварын өмнөх ашиг (алдагдал)	сая төг	5,859.8	15,871.5	59,897.1	44,025.5	277.4%	54,037.3	922.2%
8.1 Татвар тооцогдох үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая төг	35,922.8	15,871.5	46,660.4	30,788.9	194.0%	10,737.7	29.9%
9.Орлогын албан татвар	сая төг	7,106.4	3,517.9	11,739.9	8,222.1	233.7%	4,633.5	65.2%
10.Төрийн өмчийн ногдол ашиг	сая төг	-	-	1.0	1.0		1.0	0.0%
10. Цэвэр ашиг/(алдагдал)	сая төг	(1,246.7)	12,353.6	48,157.1	35,803.5	289.8%	49,403.8	-3962.9%
11.Төсвийн нийт төлбөр	сая төг	5,635.3	6,480.2	7,650.8	1,170.6	18.1%	2,015.5	35.8%
12. Орлогын 1 төгрөгт ногдох зардал	төг	0.980	0.950	0.847	(0.1)	-10.9%	(0.1)	-13.6%
13. Авлага	сая төг	23,819.4	23,113.3	27,766.1	4,652.8	20.1%	3,946.7	16.6%
14. Өглөг	сая төг	335,886.5	287,479.4	308,854.8	21,375.4	7.4%	(27,031.7)	-8.0%
15. Хөрөнгө оруулалт	сая төг	2,212.1	8,207.3	3,550.7	(4,656.6)	-56.7%	1,338.6	60.5%
16. Ажилчдын тоо	хүн	657	675	675	-	0.0%	18.0	2.7%
17. Цалингийн сан	сая төг	23,717	25,771	30,853	5,082.5	19.7%	7,136.4	30.1%
18. Дундаж цалин	мян.төг	3,008	3,182	3,809	627.5	19.7%	800.8	26.6%

